

Өнөө цагийн түгшүүр

Аймаглан устгахуй – гэдэг нь угсаатны болон шашны шинж чанараар нь хvmvвсийг устгах гэсэн торийн ухамсартай бодлого. Тийм зорилгыг Оросын эзэнт гүрэн XVIII зуунд ч, XIX зуунд ч тэр, XX зуунд ч Монгол, Хятадыг оруулан Ази тивийн газар нутаг дээр, черкесүүдийн хувьд ч тэр, оор ямарваа нэгэн ард түмэн болон угсаатны хувьд хэзээ ч тавьж байгаагүй гэдгийг тvvхч эрдэмтэд хэлдэг. Торлоор нь устгахуйг зовхон гитлерийн Германы вeд (1933-1945 он) л торийн бодлогын хэмжээнд оргомжилсэн байдаг. Орос дахь парламентын сонгуулийн онохон АНУ болон Туркийн зарим нийгэм, улс торийн зvтгэлтнvvд Барууны тэргvvлэх орон болсон Германд Османы эзэнт гүрний эвгээс нэг зуу гаруй жилийн олно армянуудыг торлоор нь устгах вйлдлийг хвлээн зовшоорсний дараа “черкесийн” гэх оор нэгэн vндэстний хозор тоглохыг оролдоцгоож байна.

Энэ нь онгорсон зууны 90-ээд оны эцсээрх бvтэлгvй оролдлогын дараахан Оросын Хойд Кавказыг тогтворгvй байдалд оруулахад чиглэгдэж байгаа буй бас нэг оролдлого юм. Гэхдээ Орос-черкесийн харилцаанд “аймаглан устгахуй” хэмээх нэр томъёог оруулах гэсэн оровдолтэй хvчин чармайлт нь Оросыг Кавказаас шахах гэсэн оорсдийнхоо геополитикийн толовлогоог хэрэгжvvлэх гэсэн зорилготой. Америкийн дэмжлэгтэй торийн эргэлтийн vр дvнд засгийн эрхэнд гарч ирсэн Михаил Саакашвили тор барих вeдээ Гvрж улс черкесүүдийг торлоор нь устгасныг хвлээн зовшоорсон нь санамсаргvй зvйл бишээ. 2014 онд монхvv Америкийн хvчний оролцоотойгоор торийн эргэлт хийсэн Украин улс энэ нэр томъёог ашиглаж хожил авахаар оролдож байна. Гэхдээ хууль эрхзvйн vүднээс 1940-оод оны хоёрдугаар хагаст эрхзvйн практикт орж ирсэн “аймаглан устгахуй /торлоор нь устгахуй/” хэмээх нэр томъёог XIX зууны вeд байсан вйл явдалд хамааруулан хэрэглэх нь зvй зохистой гэж vv. Тvvхэн баримт бичгvvдэд хандая.

1810 оны эцэс хvртэл Кавказ дахь Оросын бодлого хамгаалалтын шинж чанартай байлаа. Гэхдээ барууны тvvхийг гуйвуулагчид энэхvv баримтыг ажиглахгvй онгорохийг эрмэлзэж байна. Адегейн олон нийтийн тэргvн нарын Кавказын дайны тухай тайлбарт оруулж ирээд байгаа , “аймаглан устгах” хэмээх нэр томъёондоо хамааруулсан бараг 50 жилийн туршид Оросууд Кубань голын баруун эрэг дээр байж, черкесүүдийн газар нутагт халдаагvй богоод уулынхны оргож боссон вeд л Кубань, Лабу голыг гатладаг байлаа. Энэ бvхий л хугацааны туршид Орос улс энх тайвныг эрхэмлэн Кавказын ард түмнvvдтэй худалдаа хийхийг оролдож, тэдэнтэй зорчилд орохгvй байхыг эрмэлздэг байсан. Османы эзэнт улс (Турк) болон Ойрхи Дорнодын орнуудаас Орос улсын ялгагдах тал нь гэвэл черкесийн ард түмнийг оорийнхоо хогжилд асар том всрэлт хийхэд нь дэмжин туслаж байсан явдал юм. Оросын черкесүүд бичиг всэгтэй болж, боловсрол эзэмших бололцоотой болж, оорийн соёл, шинжлэх ухаан, утга зохиолтой болж, хожмоо

энэ нь черкесийн сэхээтэн бүрэлдэн толовшиход твлхэц болов. Тухайлахад Оросод Шора Бекмурзин Номов 1840 онд адегей хэлний зүйг, Кази Атажукин кабардин цагаан толгой, үсэглэлийг тус тус зохиосон. “Аймаглан устгах” явдалд ортсон ард түмэн оорсдийг нь устгаж байгаа засаглалын үед соёлын үнэт зүйлсийг бүтээж чадсан тохиолдол хүн торолхтний түүхэнд бий юу? Зовлолт засгийн үед черкесийн хүн ам бүхий Абхази, Адыгей, Кабардин-Балкар, Карачай-Черкес гэсэн үндэсний засаг захиргаа бүхий бүрэлдвэрүүд үүсч буй болов. Харин черкесүүд амьдран суудаг гадаадын орнуудад ийм засаг захиргааны бүрэлдвэрүүд байдаггүй аж.

ОХУ черкес угсаатны толоологчдийн эрхийг ийнхүү ажил хэрэг болгон хамгаалж иржээ. Жишээ болгоход 2008 онд Абхазын БНУ-ын тусгаар тогтнолыг хүлээн зовшоорүүлэхийн толоо 1992-1993 оны гүрж-абхазын зорчлийн үеэр олон залуус амиа алдсан баримт бий. Дахин түүх сохье. Гүржийн тусгай корпус командлагч, Кавказ болон Астрахань мужид иргэний асуудал эрхэлсэн генерал А.П. Ермоловын гол зорилго нь Оросын хамгаалалтын доор орших тосгод суурин руу чиглэсэн байнгын довтолгоог зогсоох явдал байлаа. Тэрээр чанд хатуу ажилладаг байсан ч нутгийн хүн амыг нийтээр нь хүйс тэмтрэх тухайд ямар ч яриа гардаггүй байжээ. Орос улсын бодлого бол Кавказыг эзлэх бус, харин ч тохинуулах, орон нутгийн хүн амыг бүсийн эдийн засгийн харилцаанд оруулан цаашдынх нь бие даан хөгжих үйл явцад эрч хүч огох явдал байсан юм. 1861, 1962 онуудад эзэн хаан II Александр черкесийн толоологчидтэй хоёр удаа уулзаж, тэднийг эсэргүүцлээ зогсоохыг хүсч, эзэнт улсын захиргаан дор оороо удирдах ёсыг нь хадгалуулна хэмээн баталгаа огч байлаа. 2011 оны 5-р сарын 20-нд “Черкесийн ард түмний эсрэг Оросын эзэнт гүрний явуулсан “аймаглан устгах” үйлдлийг хүлээн зовшоорч, Орос улсыг эзлэн түрэмгийлэгч, “колонилогч” хэмээн зарласан Гүржийн парламент нь Гүрж бол Хойд Кавказад Оросын байр суурийг бэхжүүлэх тэрчлэн Кавказын дайны ялалтанд хамгаас тууштай сонирхогч нь байсан гэдгийг даанч анхааралдаа авсангүй. Үүний учир нь энэ улсын арми XVIII зуунаас сайн дураараа оросын цэргийн харъялалд багтаж, оршиж ирсэнтэй холбоотой. XIX зуунд Орос болон Гүржийн улс торийн сонирхол хамгийн нягт хэлбэрээр сүлжилдсэн байлаа. Кавказад эзэнт улсын бодлогыг гол хэрэгжүүлэгч нь Гүржийн язгууртнууд гэж тооцогддог байлаа.

Гүрж гаралтай олон зуун офицерууд оросын армид алба хаадаг байв. Чухамдаа Тифлист (Тбилиси) Гүржийн тусгай (хожмоо — Кавказын) корпус байрлаж байжээ. Түүнээс гадна гүржийн хаант улс, вант улсууд уулынхантай бас л дайны байдалтай байж, тэдний дайралтанд байнга ордог байлаа. Оноодор албан ёсоор Тбилиси “черкесийн асуудлыг” оорийн улс торийн түр зуурын бодлого болгож, олон улсын тайзнаа Оросын нэр хүндийг унагаах оролдлого хийж байна. Гүржийн иймэрхүү одоон хамтгасан бодлого олон улсын хийгээд Кавказын улсууд, ард түмнүүдийн бүсийн нийгэмлэгт санаатайгаар хагарал үүсгэж байна. Адыгейн ард түмнүүдийн “гол хамгаалагчдын” дүрд тоглож буй оноогийн Гүржийн эрх баригчид XIX зуунд Хойд Кавказад болсон байлдааны үйл ажиллагаанд болон 1864 онд Красная Полянад болсон жагсаалд оросын армид алба хааж байсан олон тооны гүржийн элит офицеруудын

талаар таг дуугүй байгаа нь ичмээр. Ийм учраас тэр цаг үеийн үйл явдлын толоо шууд хариуцлагыг Гүрж бас үүрэх ёстой. Гүржийн оноо үеийн улс торчдийн олон толоологчид 1992–1993 оны Абхази дахь дайны үеэр абхаз-адегейчүүдийг устгахад оролцож байсан билээ.

Оросын черкесүүдийн олонх нь зовхон Оросод л амаар бус ажил хэрэг дээрээ үндэсний цоонхийн эрхийг дагаж морддог гэдгийг ухамсарлан Тбилисийн ивээл дор “тусгаар тогтносон черкес улс” байгуулахын эсрэг тэмцэж байлаа. ОХУ-ын ард түмнүүд оорсдийн түүх, соёл, уламжлалаа чолоотэй судлах, торолх хэл дээрээ ярих нь чолоотэй байсан. Тэр үеэр Гүржид үндэсний цоонхийг уусгах зорилготой нийтийг хамарсан “гүржжүүлэх” ажиллагаа ил цагаан явагдаж байлаа. Гүржийн засаг захиргааны арьс онгоор ялгаварлах бодлоготой үл эвлэрэх явдал нь Абхазид болон Омнод Осетинд (2008) дайн гарахад хүргэжээ. Гүржид аж торон суудаг армянууд, азербайжанчууд, грекүүд, турк-месхетинчүүд болон бусад үндэсний цоонхийн эсрэг шахалт хавчилт үргэлжилсээр байна. Тэндхийн үндэстнээс нь үл хамааран “Туркийн иргэн бүр турк хүн” гэсэн үзэл санаа бүхий үндсэн хуультай Турк улсад оноодор нохцол байдал их муу байна. Анкарагийн зүгээс албан ёсоор арьс онгоор гадуурхах бодлогод турк дэх үндэсний цоонхүүд болох күрдүүд, армянууд, грекүүд, гүржүүд ортогдсоор байна. “Черкесүүдийг аймаглан устгахуй” хэмээх санааг урагшлуулан газар авахуулахад туркийн засгийн эрх баригчдын хэмжээ хязгааргүй бялангач зан торх дохон үзүүлж байна.

Турк улс саяхан армянчуудыг аймаглан устгах үйл ажиллагаа явуулсан нь оноодор дэлхийн 29 орноор хүлээн зовшоорогдоод байна. “Черкесүүдийг аймаглан устгахуй” – н үзэл санааг дэвшүүлэгч АНУ болон түүний холбоотнуудын хүчин чармайлт нь черкесүүдийн толоо санаа тавихад бус, харин Орос улстай сорголдоход оршиж байна. Харин черкесүүдийн эмгэнэлт явдал тэдний хувьд ямарч ач холбогдолгүй юм; Дахин түүх сохож үзье. Кавказад оросууд орж ирснийг Америк болон Энэтхэгт европын колоничлогчид орж ирсэнтэй, Дорнод Европыг немцийн нацистууд булаан эзлэсэнтэй харьцуулшгүй юм. XVIII—XIX зууны үед Кавказын ард түмнүүдийг Оросын удирдлагын зүгээс бүс нутгийн бодлогын бие даасан субъектийн журмаар тууштай авч үзэж, тэдэнтэй урьд орно нь дайн хийж, энхийн хэлэлцээ, цэргийн эвсэл байгуулж байсан хэдий ч, гол нь худалдаа арилжаа хийдэг байлаа. Дэлхийн Хоёрдугаар дайны явцад нацистууд, зарим талаар Америк, Энэтхэг дэх европын колоничлогчид ч эзлэсэн нутаг дэвсгэрээ оорсдийн колони шиг үзэж, нутгийн хүн амыг зовхон эдийн засгийн “хэрэглүүр”, олонх тохиолдолд зарлагадах материал мэтээр үздэг байжээ. Колоничлогчдын үеийн америкийн индианчуудын аймшигт хувь тавилан болон 1937-1945 оны Монгол тэрчлэн Хятад дахь японы эзлэн түрэмгийлэл, мон Дэлхийн Хоёрдугаар дайны жилүүд дэх нацистын эзлэн түрэмгийллийн үеийн Орос, Украин, Белорусь, Польш, Югославийн иргэдийн хувь заяа тов тодорхой билээ.

“Черкесүүдийг аймаглан устгах” сэдэв хаанаас үүдэлтэй вэ?

Бичсэн туруу

2016 оны 6-р сарын 30, Пүрэв гариг, 11:33

Кавказын дайны үеэр үүнтэй тостэй зүйл болоогүйг түүхчид гэрчилдэг. Кавказын дайн гэж юу байсан бэ? Энэ нь түүнд оролцсон оросууд болон бусад бүхий л ард түмнүүдийн хувьд эмгэнэл байлаа. Энэ бол зовтгохийн аргагүй олон тооны үхэл хагацал бүхий урт хугацааны сорголдсон байж, тодорхой үедэд тодорхой газар нутаг дэвсгэр дээр янз бүрийн талуудад хүчний давуу тал ажиглагдаж байсан. Гэхдээ эдгээр үйл явдлууд нь эсэргүүцэл үзүүлэх чадваргүй, хамгаалалтгүй хүмүүсийг алан хядахтай огтхон ч тосоогүй байлаа. Нутгийн оршин суугчид нэг бус удаа байлдааны ажиллагааг эхлэж байлаа. Черкесүүд Кубаны баруун эрэг дээрх орос суурингуудыг дээрэмдэн тонохдоо, амьдралаа хангалуун байлгах чухал хэлбэр, аж ахуй эрхлэх гүйдлийн тогтолцооны таатай зорилго хэмээн үзэж байлаа. Түүнээс гадна хүмүүсийг боолчлолын тулд орлуулах, барьж авах явдлыг нутгийн ард түмнүүд хамгийн хүндтэй ажилд тооцдог, бараг шүтэх хэлбэрт оруулчихсан байлаа. Чухамдаа боолуудынхаа тоогоор хүний баялаг болон нийгмийн төвшинг тодорхойлдог байв.

Тиймэрхүү олзныхны хувь заяа мэдээж, туйлын гунигтай байлаа, тэднийг далайн эрэг тийш хоож тууж, Османы эзэнт улсад (Турк) худалддаг байв. Оросуудыг Кавказад ирэхээс өмнө адегейн нийгэмлэг нэгдмэл бус байлаа, энэ талаар энэ нутагт ирж байсан эрдэмтэд, аялагчид дурдсан байдаг. Кавказын дайн эхлэхээс өмнө тус бүс нутагт янз бүрийн нийгмийн болон үндэстний бүлгүүд сорголддог байсан нь адегейн нийгмийг нэгдмэл улс болгон төлөвших бололцоог олгосонгүй. Дайны эхэнд нэгдмэл кавказын нийтлэг байхгүй байсан учраас Кавказын дайныг “чолоолох”, эсвэл “орос-черкесийн”, тэр ч байтугай “орос-кавказын” хэмээн нэрлэхэд тохиромжгүй юм. Энэхүү том дайн нь хэд хэдэн тулалдаанаас бүрэлдэх ба үлэмж хэжээгээр Оросын хувьд ч, Кавказын ард түмнүүдийн хувьд ч иргэний дайны шинжтэй байсны учир нь Оросын эзэнт гүрний албанд орон нутгийн хүн амын орон тооны анги нэгтгэлүүд оролцдог байв.

Кавказын дайны туршид Оросын талд олон тооны адыгей-мусульманчууд байлдаж байлаа, дайны эцэс гэхэд Шамилын нолоон дор Оростой хийсэн дайн “сүсэггүйтний” эсрэг шашны шинж чанартай болсон байв. Олон тооны эгэл жирийн уулынхан Оросын талд орж, боол эзэмшлийн тогтолцооноос гарч, хувийн эрх чөлөө олж авахын тулд казак хэмээн бүртгүүлдэг байжээ. Эндээс харахад черкесийн ард түмнийг “аймаглан устгах” гэгч сэдэв нь Кавказын бүс нутаг дахь Баруун болон АНУ-ын бодлогын еронхий дэвсгэрт орж байна. Хар тэнгис НАТО-гийн бүрэн хяналтаас гарсан үед, черкесүүдийг “аймаглан нь устгах” гэгч сэдэв “хэрэгтэй цагтаа, хэрэгтэй газраа” байнга гарч байх нь ойлгомжтой болоод байна.

<https://regnum.ru/news/polit/2138171.html> Дмитрий СОКОЛОВ.

“Черкесүүдийг аймаглан устгах” сэдэв хаанаас үүдэлтэй вэ?

Бичсэн турш

2016 оны 6-р сарын 30, Пүрэв гариг, 11:33

Орос хэлнээс орчуулсан Наваанзоч Х.Цэдэв